

ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээг ХЗДХЯ-аас Шүүхийн шинжилгээний хүрээлэнтэй хамтран боловсруулсан “Шүүх шинжилгээний тухай” хуулийн төслийн зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн^[1] 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор гүйцэтгэлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь хуулийн шинэчилсэн найруулгын төсөл^[2] хэлбэрээр боловсруулагдсан байна.

Шүүх шинжилгээний тухай хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”^[3]-д /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шатаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д^[4] заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтээс дараахь 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо.

Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Ойлгомжтой байдал;
4. Харилцан уялдаа зэрэг болно.

Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:

➤ Зорилгод хүрэх байдал:

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь тухайн хуулийн төслийн зохицуулалт анх дэвшүүлсэн зорилго буюу тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох билээ. Иймд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг

тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

➤ **Практикт хэрэгжих боломж:**

Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан шүүх шинжилгээ хийх үндэслэл, журам, шинжилгээний онцлог зохицуулалт, шинэ төрлийн шинжилгээний журам, шүүх шинжилгээний байгууллагын тогтолцоо, чиг үүргийг шинэчилсэн байна.

Түүнчлэн зарим төрлийн хохиролд үнэлгээ тогтоох журам, шинжээчийн эрх олгох, түдгэлзүүлэх, сунгах, цуцлах журам, шүүх шинжилгээний байгууллагын алба хаагчдын эрх зүйн байдлыг шинээр тогтоож, тэдэнд тавигдах шаардлагыг тодорхойлж, адестачлал хийх, давтан сургах зохицуулалтыг зохицуулсан.

Мөн шүүх шинжилгээний байгууллагаас гадуур хийх шинжилгээний эрх зүйн орчин тодорхой болгож, шүүх шинжилгээний байгууллагаас гадуур хийх шинжилгээний шинжээчид эрх олгохтой холбоотой зохицуулалтыг төсөлд тусгасан байна.

Иймд эдгээр шинэлэг зохицуулалт нь хэрэгжих боломжтой эсэхийг тодруулах шаардлагатайг харгалзан тус шалгуур үзүүлэлтийг сонгосон.

➤ **Ойлгомжтой байдал:**

Хуулийн зохицуулалт нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектын хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг.

Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбараар томъёологдсон байх шаардлага тавигддаг.

Энэхүү хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд^[5] заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

➤ **Харилцан уялдаа:**

Хуулийн төслийн эх бичвэр нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой, мөн төсөлд тусгагдсан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилгүй байх, хуулиар үүрэг хүлээсэн субъектүүдын чиг үүрэг давхардал, зөрчилдөөнгүй байх шаардлагатай.

Иймд хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан агуулгын шаардлагыг^[6] хангасан эсэхийг шалгах зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгож байна.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал болон зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг сонгоогүй тухай:

Шүүхийн шинжилгээний тухай хууль нь 2009 оны 12 дугаар сарын 03-ны өдөр батлагдсанаас хойш нийт 5 удаа, давхардсан тоогоор 40 гаруй зүйл, хэсэг, заалтад нэмэлт, өөрчлөлт орж хуулийн анхны бичвэрээс нэлээд зүйл, заалт өөрчлөгдсөн байна. Эдгээр өөрчлөлтийн тухайд уг хуулийн агуулга, үзэл баримтлалыг өөрчлөхөд бус харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль зэрэг процессын хуулиудад оруулсан нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан хийгдсэн байна.

Дээрх нэмэлт, өөрчлөлтөөр хуулийн зүйл, хэсэг, заалтын уялдаа холбоо алдагдах, нэг мөр ойлгож хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, шинээр нэр томъёог хэрэглэх болсон зэрэг зарим зохицуулалт хангалттай бус байна.

Шүүхийн шинжилгээний тухай хуулиар шүүхийн шинжилгээний байгууллага нь эрүү, иргэн, захиргааны хэрэг маргааныг хянан шийдвэрлэх болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн гэж заасан боловч хуульд эрүү, иргэн, захиргааны хэрэгт хийх шинжилгээний зарим онцлог зохицуулалтыг тусгаагүй, нийгмийн хөгжлийг даган инженер техник, хүрээлэн байгаа орчин, цахим төхөөрөмж гэх мэт зарим тусгай мэдлэг шаардагдах онцлог шинжилгээг хэрхэн хийх талаарх зохицуулалт хуульд тодорхой бус байна.

Гэтэл тусгай мэдлэг шаардсан онцлог зохицуулалт бүхий шинжилгээг хийх шаардлагатай гэмт хэргийн тоо жил бүр өсөж байна.

Түүнчлэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад шүүх шинжилгээ хийх практик шаардлага гардаг ч эрх зүйн зохицуулалт байхгүй тул хийгдэлгүй явагддаг байна.

Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, төслийн зорилт, зохицуулалтаас үзэхэд шүүх шинжилгээ хийх, хүрээлэн байгаа орчны хохирлыг тооцох болон сэтгэгцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох, шинжилгээ хийх эрх олгох үндэслэл, журам болон шүүх шинжилгээний байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, алба хаагчийн эрх зүйн байдлыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахаар байна.

Түүчлэн шүүхийн шинжилгээний байгууллагаас хийх шинжилгээг төлбөргүй болгон өөрчилж, зөвхөн төрийн байгууллага иргэд, байгууллагад үйлчилгээ үзүүлсний төлөө хураамж авах зарчмыг тодорхой төрлийн үйлчилгээнд үзүүлэхээр зарчмыг баримтлахаар байна.

Иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад шүүх шинжилгээг хийх эрх зүйн орчныг бүрдүүлэхээр тусгасан байна.

Иймд хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтын хүрээнд хамрагдах этгээд (иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэхийг тодруулах зорилт бүхий **“хүлээн зөвшөөрөгдөх байдал”** шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно.

Мөн дээрх үндэслэлээс гадна тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоог тусгайлан хийх тул цаг хугацаа, нөөцийн хэмнэлт хийх үүднээс **“зардал тооцох”** шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо.

Хүснэгт-1

д/ д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 8, 11, 40, 49 дүгээр зүйл	Хуулийн зохицуулалтад хамрагдах байгууллагын төлөөлөлтэй ярилцлага зохион байгуулах, статистик мэдээ, хуулийн төсөлд ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийх.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
4	Харилцан уялдаа	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан шалгах.

1. Зорилгод хүрэх байдлыг хангасан эсэх:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Шүүх шинжилгээний тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад тухайн хуулийн төслийн зорилго, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийхийг зорьсон.

Энэ дагуу Шүүхийн шинжилгээний тухай хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн^[7] зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн үзэл баримтлал^[8], хуулийн төслийн бүтэц, зохицуулах зүйлийн хүрээ, агуулгад дүн шинжилгээ хийж үзвэл Шүүхийн шинжилгээний тухай хуулийн зохицуулалтыг өргөжүүлж, дараах зорилтуудад тулгуурлан шинэчлэхээр зорьсон байна:

- 1) Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Цагдаагийн албаны тухай хуулийн нэр томьёотой нийцүүлж, шинээр нэмж томьёолно;
- 2) Шүүх шинжилгээний нийтлэг журмыг боловсронгуй болгож, шинжилгээний хугацааг жишиг хугацааг үндэслэн тогтоох, хугацааг сунгах эрх зүйн орчныг тодорхой болгоно;
- 3) Шүүх шинжилгээний хэлбэр, төрлийг шинээр тодорхойлж, шинжилгээний адилтгал, мэдээллийн сан, түүний төрөл, бүрдүүлэлт, ашиглалт, хамгаалалтын эрх зүйн орчныг шинээр бүрдүүлнэ;
- 4) Шүүх шинжилгээний байгууллагад болон бусад этгээдээр хийлгэх шинжилгээг тодорхойлж, шинжилгээг хийх шинжилгээний байгууллагаас бусад этгээдийг шинжлэн магадлахуйн сургалтад хамруулах, тэдэнд шинжээчийн эрх олгох, түдгэлзүүлэх, хасахтай холбоотой харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг бүрдүүлнэ;
- 5) Эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны явцад хийх шинжилгээний зарим онцлог зохицуулалт болох инженер-техникийн шинжилгээ, хөрөнгийн үнэлгээнд хийх шинжилгээ, цахим технологийн шинжилгээ хийх зохицуулалт, журмыг шинээр тусгана;
- 6) Хүрээлэн байгаа орчин болон сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлөх төлбөрийг тогтоох үнэлгээг хийх эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинээр бүрдүүлнэ;
- 7) Сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлөх төлбөрийг тогтоох үнэлгээг шүүхээс хэрэглэхдээ сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох жишиг аргачлалыг баримтлах, уг аргачлалыг батлах субъектыг тодорхой болгоно;
- 8) Шүүх эмнэлгийн төлбөртэй явуулж байсан шинжилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх, төрийн байгууллагаас үзүүлсэн үйлчилгээнд улсын тэмдэгтийн хураамжийг авах зохицуулалтыг тусгана;
- 9) Шүүх шинжилгээний байгууллага, түүний тогтолцоо, шинжилгээний байгууллагын ажилтны эрх зүйн байдлыг шинээр томьёолон оруулж, алба хаагчийн баталгааг нарийвчлан тодорхойлно.

Дээр дурдсан зорилтуудыг хангах чиглэлээр тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байдлыг шалгаж үзвэл:

- o *Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Цагдаагийн албаны тухай хуулийн нэр томьёотой нийцүүлж, шинээр нэмж томьёолох хүрээнд:*

Шүүхийн шинжилгээний тухай хууль^[9] 2009 оны 12 дугаар сарын 03-ны өдөр батлагдсанаас хойш нийт 6 удаа, давхардсан тоогоор 40 гаруй зүйл, хэсэг, заалтад нэмэлт, өөрчлөлт орж, хуулийн анхны бичвэрээс нэлээд өөрчлөгдсөн хэдий ч эдгээр өөрчлөлтүүд нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль зэрэг процессын хуулиудад

оруулсан нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан хийгдсэн учир уг хуулийн агуулга, үзэл баримтлалд өөрчлөлт ороогүй.

Харин дээрх нэмэлт, өөрчлөлтөөр хуулийн зүйл, хэсэг, заалтын уялдаа холбоо алдагдах, нэг мөр ойлгож хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, шинээр нэр томъёог хэрэглэх болсон зэрэг зарим зохицуулалт хангалттай бус байна.

Түүнчлэн шинээр батлагдан мөрдөж эхэлсэн Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчлийн хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудад Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасан шинжээжилгээг хийхтэй холбоотой нийтлэг зохицуулалт, шинжээчийн эрх үүрэг, түүнд хориглох зүйл, шинжилгээний объектын талаарх зохицуулалт зэргийг агуулгын болон хэлбэрийн хувьд давхардуулан заасан Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.7 дахь заалтад бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байхаар заасантай нийцэхгүй байна.

Мөн Шүүхийн шинжилгээний тухай хуулийн нэр томъёо нь дээрх хуулиудад өөрөөр томъёолсон байсан. Тухайлбал, Шүүхийн шинжилгээний тухай хуульд шинжилгээ хийх, дүгнэлт гаргах гэдэг нэр томъёогоор орсон бол бусад процесс хуулиудад шинжээч томилох гэдэг нэр томъёогоор орсон нь нэг агуулгыг хоёр өөр нэр томъёогоор хэрэглэж байсан байна.

Харин хуулийн төсөлд Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан шүүх шинжилгээ хийхтэй холбоотой харилцаанд хэрэглэх нэр томъёог жигдэлсэн байна. Ингэж хуулийн төсөл болон хуулийн нэр томъёог жигдлэхдээ шүүх шинжилгээ хийх нийтлэг журмыг тодорхойлох, шинжээчийг томилох, хугацааг сунгах, шинжилгээний дүгнэлтийг гаргах зэрэг уг харилцааг зохицуулсан голлох холбоотой зохицуулалтыг Шүүх шинжилгээний тухай хуулийн төсөлд нэгтгэн нарийвчлан тусгаж, харин процессийн хуулиудад дээрх хуулийг эшлэх байдлаар тусгасан байна. Тухайлбал, хуулийн төслийн 6 дугаар зүйл Шинжилгээ хийх үндэслэл, 7 дугаар зүйл Шинжилгээ хийлгэх шийдвэр гаргах, 9 дүгээр зүйл Шинжилгээг шинжилгээний байгууллагаар хийлгэх, 10 дугаар зүйл Шинжилгээг шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээдээр хийлгэх, 16 дугаар зүйл Шинжилгээ хийх хугацаа, 18 дугаар зүйл Шинжээчийн дүгнэлтийн агуулга зэрэг зохицуулалтыг хуулийн төсөлд нарийвчлан тусгасан тул Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай зэрэг процесс хуулиас хасаж, Шүүх шинжилгээний тухай хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалтыг эшлэсэн байна.

Энэ нь нэг талаар Шүүх шинжилгээний хуулийн төсөлд шүүх шинжилгээ хийхтэй холбоотой бүхий л харилцааг зохицуулсан зохицуулалтыг нэгтгэн тусгасан ойлгомжтой боловч хууль хэрэглээний явцад техникийн шинжтэй хүндрэл гарч болзошгүй юм. Өөрөөр хэлбэл процессийн хуульд шинжилгээ хийх шийдвэр гаргах, шинжээчийн дүгнэлтийн агуулга, шинжилгээ хийх хугацааг тогтоох зэрэг зарим процессийг тоочин заагаагүй

болохоор заавал Шүүх шинжилгээний тухай хуулийн эшлэсэн заалтыг татаж үзэх шаардлагатай болно.

Шүүх шинжилгээний тухай хуулийн төсөлд зарим нэр томьёо нь зөрүүтэй хэвээр байгааг анхаарах нь зүйтэй. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д “шинжээч” гэж шүүх шинжилгээ хийж, дүгнэлт гаргахаар хуульд заасан журмын дагуу томилогдсон тусгай мэдлэг бүхий хүнийг ойлгохоор заасан байна. Харин хуулийн төслийн 4.1.7, 8.2, 10.3, 10.4, 17.2, 26.2, 48.1.1, 48.1.2, 48.2.1-д тусгай мэдлэг эзэмшсэн хүн, тусгай мэдлэг бүхий хүн, тусгай мэдлэг эзэмшсэн иргэн гэх зэргээр нэр томьёог өөр өөрөөр тусгасан байна. Мөн хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн гарчигт шинжилгээ хийх эрх олгох зохицуулалтыг тусгасан боловч 11 дүгээр зүйлд “шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл” гэж, мөн хуулийн төслийг даган боловсруулсан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1.1-д “шинжээчийн эрхийн зөвшөөрөл”, 11.5 дахь хэсэгт шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл зэргээр өөр өөр нэр томьёогоор нэг зүйлийг тодорхойлсон байна.

Иймд хуулийн төслийн дээр дурдсан зүйл, хэсэг, заалтын нэр томьёог жигдэлж, ойлгомжтой болгох шаардлагатай байна.

- о Шүүх шинжилгээний нийтлэг журмыг боловсронгуй болгож, шинжилгээний хугацааг жишиг хугацааг үндэслэн тогтоох, хугацааг сунгах эрх зүйн орчныг тодорхой болгох хүрээнд:

Хуулийн төслийн 14 дүгээр зүйлд Шинжилгээ хийх буюу шинжилгээ хийх нийтлэг журмыг заасан байна. Ингэхдээ Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасан шинжилгээ хийх нийтлэг журмыг өргөжүүлэн боловсронгуй болгож хуулийн төсөлд тусгасан байна. Өөрөөр хэлбэл хуулийн төслийн 4.1-д шинжилгээг зөвхөн батлагдсан шинжилгээ хийх үйл ажиллагааны стандарт, журмын дагуу хийх, 14.5-д лабораторид хийгдэх шинжилгээг техник, тоног төхөөрөмж бүхий стандартын шаардлага хангасан орчинд хийх, 14.7-д лабораторийн үзлэг шинжилгээний явцыг дууны, дүрсний, эсхүл дуу-дүрсний аргаар бэхжүүлж, архив үүсгэн хадгалах зохицуулалтыг тусгасан байна. Мөн шинжилгээ хийх журмыг батлах субъектыг тодорхойлсон байна.

Үүнээс гадна уг зүйлд шинжилгээний объектод шинжилгээ хийх явцад гэмтэл, хорогдол үүсэхээр байвал энэ талаар шинжилгээ хийх шийдвэр гаргасан этгээдэд заавал мэдэгдэхээр тусгасан байна. Энэ нэг талаас шинжилгээний байгууллага, шинжээчийн нотлох баримт буюу шинжилгээний объектод зөв зүйтэй харьцах, хамгаалах, тухайн объектыг гэмтээх, устгахаас зайлс хийхийг үүрэгжүүлсэн болно. Нөгөө талаас шинжилгээний явцад шинжилгээний объектод үүсдэг гэмтэл, хорогдлыг зүй ёсны хорогдол байхаар хуулийн төсөлд тусгаж өгсөн нь шинжээч, шинжилгээний байгууллагыг хамгаалсан, зүй ёсны болон зүй ёсны хорогдлын зааг ялгааг гаргасан зохицуулалт болсон байна. Хэрэв зүй ёсны бус буюу шинжилгээний объектыг гэмтээсэн, устгасан бол хуульд заасан хариуцлагыг шинжээч хүлээхээр заасан байна.

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шинжилгээний объектын тоо хэмжээ, шинжилгээний цар хүрээ, онцлогийг харгалзан шинжилгээ хийх жишиг хугацааг үндэслэн шинжилгээ хийх хугацааг тогтоохоор заасан байна.

Одоо мөрдөж байгаа Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт “Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд нь объектын тоо хэмжээ, шинжилгээний цар хүрээ, онцлогийг харгалзан шинжилгээ хийх хугацааг тогтооно” гэж заасан ч шинжээчийг томилж байгаа этгээд шинжилгээний төрөл, хэлбэр, онцлог, цар хүрээ, объектын тоо хэмжээ зэргийг харгалзан үзэхгүй байгаа нь шинжилгээ хийх үйл ажиллагаанд хүндрэл учруулж, шинжилгээний үр дүнд сөргөөр нөлөөлөхөд хүргэдэг байна.

Түүнчлэн шинжилгээ хийлгэж байгаа мөрдөгч, прокурор, шүүгч, шүүх болон хуульд заасан эрх бүхий этгээдийн зүгээс бүх төрлийн шинжилгээг хийх хугацааг 3-5 хоногийн хугацаатайгаар тогтоож байгаа нь нэг талаас эдгээр субъектэд шинжилгээ хийх хугацааг тогтоох давуу эрхийг хуулиар олгосонтой холбоотой.

Нөгөө талаас шинжилгээ хийх хугацааг тогтоохдоо шинжилгээний байгууллагаас хүргүүлсэн жишиг хугацааг харгалзан үзэх тухай хуульд нарийвчилсан зохицуулалт байхгүй. Иймд шинжилгээг хийлгэх эрх бүхий этгээд шинжилгээг хийх хугацааг тогтоохдоо тухайн шинжилгээний төрөл, цар хүрээ, объектын тоо хэмжээ, онцлогийг харгалзан шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоосон шинжилгээ хийлгэх жишиг хугацааг үндэслэж байхаар хуулийн төсөлд заасан байна.

Хуулийн төсөлд оруулсан жишиг хугацааг үндэслэн хугацааг тогтоох зохицуулалт нь шинжилгээний бодитой, шинжлэх ухааны үндэслэлтэй гарах, нөгөө талаар хугацаа сунгах албан бичгийг төлөвлөн шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд хүргүүлэх зэрэг зохиомол ачааллыг багасгах давуу талтай байна. Харин хэрэг, зөрчил, маргааныг шийдвэрлэх хугацааг хойшлуулах сөрөг талтай байж болох юм. Гэхдээ шүүх шинжилгээний дүгнэлт нь тухайн хэрэг, зөрчил, маргааныг шийдвэрлэх гол нотлох баримт болох тул дээр дурдсан сөрөг талыг зохион байгуулалтын арга хэмжээгээр багасгаж болох юм.

Түүнчлэн хугацаа сунгахдаа шинжилгээ хийлгэх шийдвэр гаргах эрх бүхий этгээд зөвхөн шинжилгээ хийлгэх эрх бүхий бусад этгээдийн хийж байгаа шинжилгээний хугацааг тэдний хүсэлтийн дагуу сунгахаар заасан байна. Харин шинжилгээний байгууллага дээр хийгдэж байгаа шинжилгээний хугацаа сунгах асуудлыг шинжилгээний байгууллагын шинжээчийн хүсэлтийг үндэслэн дээд шатны албан тушаалтан сунгаж, энэ тухай шүүх, прокурор, мөрдөн байцаагч, эрх бүхий этгээдэд (мэргэжлийн хяналтын улсын байцаагч) мэдэгдэхээр зохицуулсан байна.

Энэ нь нэг талаар байгууллага хооронд хугацаа сунгах хүсэлтийг илгээж шинжилгээ хийх хугацааг алдагдуулахаас сэргийлсэн сунгах техник хугацааг багасгасан ач холбогдолтой гэж харж байна. Энэхүү өөрчлөлттэй холбоотойгоор процесс хуулиуд болох Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан

Дээрх шинжилгээний хугацааг жишиг хугацааг баримтлан шинжилгээ хийх хугацааг тогтоох нь хуулийн төслийн 5.1.5-д заасан шинжилгээг тал бүрээс нь бүрэн, бодитой, шинжлэх ухааны үндэслэлтэй хийх зарчимтай бүрэн нийцэж байна. Өөрөөр хэлбэл шүүх шинжилгээг хийж, дүгнэлт гаргахдаа шинжилгээний жишиг хугацааг удирдлага болгон

шинжилгээг шинжилгээний үр дүнд нөлөөлөхөөргүй боломжит богино хугацаанд шуурхай хийж гүйцэтгэх, шинжээч нь шинжилгээг хийхдээ шинжлэх ухааны үндэслэл бүхий арга аргачлал, шинжилгээ хийх үйл ажиллагааны стандартыг баримтлан шинжилгээг тал бүрээс нь бүрэн бодиттой хийж, дүгнэлт гаргах бөгөөд дүгнэлтийн үндэслэлийг шинжээч өөрөө хариуцахтай нийцэхээр байна.

Харин хуулийн төсөлд шинжилгээ хийх жишиг хугацааг эрх бүхий этгээдээс батлахаар заасан бөгөөд шинжилгээ хийх жишиг хугацаа нь нэг ерөнхий хугацаа байхаар ойлгогдож байхаас гадна уг хугацааг хэн боловсруулах нь тодорхойгүй байна. Тухайлбал, хуулийн төслийн 16.7-д шинжилгээ хийх жишиг хугацааг Улсын Ерөнхий прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлахаар заасан байна.

Иймд хуулийн төслийн 16 дугаар зүйлд шинжилгээ хийх жишиг хугацааг ерөнхий нэг хугацаа байхаар ойлгогдож байгаа өөрчилж, шинжилгээ хийх жишиг хугацааг шинжилгээний төрөл тус бүрээр гаргах байдлаар зохицуулалтыг тусгах, түүнчлэн уг хугацааг боловсруулах, эсхүл батлах эрх бүхий этгээдэд санал болгох этгээдийг тодорхой тусгах шаардлагатай байна. Тухайлбал, шинжилгээ хийж, дүгнэлт гаргах үндсэн чиг үүрэг бүхий байгууллага буюу шүүх шинжилгээний байгууллагаас шинжилгээний жишиг хугацааг боловсруулан гаргах зүйтэй.

- о Шүүх шинжилгээний хэлбэр, төрлийг шинээр тодорхойлж, шинжилгээний адилтгал, мэдээллийн сан, түүний төрөл, бүрдүүлэлт, ашиглалт, хамгаалалтын эрх зүйн орчныг шинээр бүрдүүлэх хүрээнд:

Хуулийн төслийн 25 дугаар зүйлийн 25.1-д “Шинжилгээ нь анхдагч, нэмэлт, дахин гэсэн хэлбэртэй байна.”, 26 дугаар зүйлийн 26.1-д “Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд анхдагч шинжилгээг нэг, түүнээс дээш шинжээчийн бүрэлдэхүүнтэй багаар хийлгэж болно.”, 27 дугаар зүйлийн 27.1-д “Шинжээчийн дүгнэлт бүрэн бус, эсхүл шинжилгээ хийлгэж байгаа асуудалтай холбоотой шинэ нөхцөл байдал бий болсон тохиолдолд шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн шийдвэрээр нэмэлт шинжилгээ хийнэ.”, 28 дугаар зүйлийн 28.1-д “Шинжээчийн дүгнэлт, түүний зарим хэсэг үндэслэлгүй, эсхүл үндэслэлтэй эсэх нь эргэлзээтэй байвал шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн шийдвэрээр дахин шинжилгээ хийнэ.”, 29 дүгээр зүйлийн 29.1-д “Шаардлагатай тохиолдолд шинжилгээг ижил, эсхүл өөр мэргэжлийн хоёр, түүнээс дээш шинжээчийн бүрэлдэхүүнтэй багаар хийлгэж болно.” гэж тус тус заасан байна.

Шүүх шинжилгээний хэлбэрийг анхдагч, давтан шинжилгээ, багаар хийх шинжилгээ зэргээр ангилал, төрлийг тодорхой болгож, тус бүрийн онцлогийг харуулсан зохицуулалтыг төсөлд тусгасан.

Түүнчлэн шинжилгээний адилтгал, мэдээллийн сан, түүний төрөл, ашиглалт, хамгаалалттай холбоотой харилцааг нарийвчлан хуулийн төсөлд тусгасан. Тухайлбал, шүүхийн шинжилгээ адилтгал, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, ашиглах хамгаалах зохицуулалтыг шинжилгээний адилтгал, мэдээллийн төрөлжсөн сангийн зохицуулалтыг тухайн мэдээллийн сангийн ашиглалт, бүрдүүлэлтийн ялгаатай байдлаар тусгасан байна.

Үүнээс дүгнэхэд шинжилгээний хэлбэрийг анхдагч, нэмэлт, дахин гэж ялгаатай байдлаар ялангуяа анхдагч шинжилгээг шинээр тодорхойлсон байх бөгөөд тус бүрийн

хэлбэрийг нэг шинжээч, эсхүл багаар буюу бүрэлдэхүүнтэйгээр хийж болох нөхцөл заасан нь дэвшилттэй болсон байна. Түүнчлэн шинээр дахин шинжилгээ хийхэд анхдагч болон нэмэлт шинжилгээнд ирүүлсэн шинжилгээний объектыг бусад холбогдох материалын хамт ирүүлэхээр заасан нь дахин шинжилгээ хийх тусгай шаардлагыг тусгасан нь практикт гардаг хийдлийг арилгасан зохицуулалт болжээ. Өөрөөр хэлбэл, дахин шинжилгээнд ирүүлж байгаа объект нь анхан шинжилгээнд ирүүлсэн объектоос өөр объект ирэх тохиолдолд ихээхэн гардаг бөгөөд тухайн объектоос шалтгаалан шинжилгээний үр дүн, шинжээчийн дүгнэлт өөр гардаг. Үүний улмаас дахин шинжилгээг бүрэлдэхүүнтэй хийх зэргээр сөрөг үр дагавар их үүсдэг байсныг өөрчлөх шинжилгээний үр дүнг сайжруулах бодитой болох зохицуулалт болсон байна.

Хуулийн төслийн 28 дугаар зүйлийн 28.5-д дахин шинжилгээний үр дүн анхдагч, нэмэлт шинжилгээний үр дүнтэй адил бол дахин шинжилгээ хийхгүй байх зохицуулалтыг шинээр тусгасан нь шинжилгээний үр дүнд суурилан хэргийг хурдан шуурхай шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн зохицуулалт болсон байна. Өөрөөр хэлбэл хэргийн оролцогчийн хүсэлтээр дахин дахин шинжилгээг хийж, цаг хугацаа алдах үр дагаврыг хязгаарласан байна.

Харин хуулийн төслийн 30 дугаар зүйлийн 30.1-д “ижил мэргэжлийн шинжээчдийн баг хоёр, эсхүл түүнээс дээш тав хүртэлх шинжээчийн бүрэлдэхүүнтэй байна” гэж заасан нь ижил мэргэжлийн шинжээчдийн багаар шинжилгээг хийхдээ таваас дээш тооны шинжээчдийг оруулахыг хязгаарласан заалт болжээ. Энэ нь шинжилгээний объектын цар хүрээ, ээдрээ төвөгтэй байдлаас шалтгаалан таваас дээш тооны ижил мэргэжлийн шинжээчдээр шинжилгээг хийлгэх боломжийг үгүй хийж, шинжээчдийн багийн ачааллыг зохиомлоор нэмэгдүүлэх зохицуулалт болсон байна гэж үзэж байна. Мөн дахин шинжилгээ хийх тохиолдолд шинжээчдийн багийн бүрэлдэхүүн нь 5 шинжээчээ дээш байж болохгүй хязгаарлалтыг үүсгэж байна.

Иймд хуулийн төслийн 30 дугаар зүйлийн 30.1 дахь хэсгийн “тав хүртлэх” гэсэн шинжээчдийн тооны хязгаарлалтыг хасаж, хоёроос дээш хэд ч тооны шинжээчдийн бүрэлдэхүүнтэй хийж болох нөхцөлийг хангах нь шаардлагатай байна.

Энэ үзэл баримтлалын зохицуулалтын хүрээнд адилтгал мэдээллийн нэгдсэн болон төрөлжсөн сан, түүнийг хадгалах, хамгаалах холбоотой асуудлыг авч үзэх нь зүйтэй.

Хуулийн төслийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Шинжилгээний байгууллага нь шинжилгээ хийж, дүгнэлт гаргахад шаардлагатай шинжилгээний адилтгал, мэдээллийн сантай байна.”, 22.2-т “Шинжилгээний адилтгал, мэдээллийн сан нь нэгдсэн болон төрөлжсөн сангаас бүрдэнэ.”, 23 дугаар зүйлийн 23.1-д “Шинжилгээний адилтгал, мэдээллийн нэгдсэн санг улсын хэмжээнд, төрөлжсөн санг шинжилгээний лабораторид үүсгэж хөтөлнө.”, 23.2-д “Шинжилгээний байгууллага энэ хуулийн 22.3, 22.4-т зааснаас бусад төрлийн шинжилгээний адилтгал, мэдээллийн нэгдсэн болон төрөлжсөн сан шинээр үүсгэж болно.” 23.3-т “Шинжилгээний байгууллага шинжилгээний адилтгал, мэдээллийн нэгдсэн болон төрөлжсөн санг шинэчлэх, санд мэдээлэл цуглуулах, боловсруулах ажлыг төрийн байгууллага, хуулийн этгээдтэй хамтран зохион байгуулна.”, 23.4-т “Хуульд өөрөөр заагаагүй бол шинжилгээний байгууллага төрийн байгууллага,

хуулийн этгээд шинжилгээний адилтгал, мэдээллийн санд шаардлагатай бүтээгдэхүүний эх хувь, тэдгээрийн мэдээлэл, танилцуулгыг гаргуулан авна.”, 23.5-д “Шаардлагатай тохиолдолд шинжилгээний байгууллага зарим төрлийн шинжилгээний объект, харьцуулах загварыг шинжилгээний адилтгал, мэдээллийн нэгдсэн болон төрөлжсөн санд авч болно.”, 23.6-д “Шинжилгээний байгууллага шинжилгээний адилтгал, мэдээллийн нэгдсэн санг шинжилгээ хийж, дүгнэлт гаргах, эсхүл эрх бүхий байгууллагад лавлагаа мэдээлэл өгөх зорилгоор ашиглана.”, 23.7-д “Шинжилгээний адилтгал, мэдээллийн төрөлжсөн санг шинжилгээний байгууллага шинжилгээ хийхэд ашиглана.”, 23.8-д “Шинжилгээний байгууллага энэ хуулийн 23.6, 23.7-д зааснаас бусад зорилгоор шинжилгээний адилтгал, мэдээллийн санг ашиглахыг хориглоно.”, 23.9-д “Хуульд өөрөөр заагаагүй бол шинжилгээний байгууллагын шинжээч -шинжилгээ хийж, дүгнэлт гаргахдаа бусад байгууллагын мэдээллийн санг ашиглаж болно.” гэж тус тус заасан байна.

Дээрх адилтгал, мэдээллийн нэгдсэн болон төрөлжсөн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, ашиглах, хамгаалах, мөн холбогдох дүрэм, журмыг батлах эрх бүхий этгээдийг тусгаж өгсөн шинэлэг зохицуулалтыг бүрдүүлжээ.

Гэвч хуулийн хуулийн төслийн 22 дугаар зүйлийн 22.3.5, 22.4.8-д “бусад” гэж тодорхойгүй “цонх” үүсгэсэн байгааг анхаарах нь зүйтэй байна. Энэ нь тухайн бусад ямар төрлийн мэдээлэл орох нь тодорхойгүй байгаа бөгөөд ямар мэдээллийг бүрдүүлэх, хадгалах, ашиглах хамгаалах нь мөн адил тодорхойгүй болж байна.

Иймд шинжилгээний адилтгал, мэдээллийн нэгдсэн болон төрөлжсөн санд орох мэдээллийг бүгдийг тоочих байдлаар хуулийн төсөлд тусгах шаардлагатай байна.

- о Шүүх шинжилгээний байгууллагад болон бусад этгээдээр хийлгэх шинжилгээг тодорхойлж, шинжилгээг хийх шинжилгээний байгууллагаас бусад этгээдийг шинжлэн магадлахуйн сургалтад хамруулах, тэдэнд шинжээчийн эрх олгох, түдгэлзүүлэх, хасахтай холбоотой харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд:

Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1-д шинжилгээг шинжилгээний байгууллагаар, эсхүл шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээдээр хийлгэнэ.”, “Шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээдэд тухайн хэрэгт хувийн ашиг сонирхолгүй тусгай мэдлэг эзэмшсэн хүн, энэ хуулийн 11.1-д заасны дагуу эрх авсан шинжээч, эсхүл тусгай мэдлэг эзэмшсэн мэргэжилтэн, мэргэжлийн байгууллага /цаашид “мэргэжлийн байгууллага” гэх/ хамаарна.”, 8.3-т “шинжилгээний байгууллагад хийх шинжилгээний жагсаалтыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”, 8.4-т “шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээдээр хийлгэж болох шинжилгээний жагсаалтыг шинжилгээний байгууллагын саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж заасан байна.

Шүүх шинжилгээний тухай хуулийн төслийн нэг гол үзэл баримтлал бол шинжилгээг шинжилгээний байгууллагаас бусад этгээд буюу шинжилгээ хийх эрх авсан шинжээч хийж болохоор заасан байна. Харин тухайн этгээдийн хийж болох шинжилгээний жагсаалтыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар заасан.

Харин шинжилгээний байгууллагын хийх шинжилгээний жагсаалтыг шинжилгээний байгууллагын саналыг үндэслэхээр заах нь зүйтэй байна.

Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан тусгай мэдлэг эзэмшсэн мэргэжилтэн, эсхүл хүн нь шинжилгээг хийхээр заасан бол уг хэсэгт мөн мэргэжлийн байгууллага шинжилгээг хийхээр заасан байна. Гэтэл мэргэжлийн байгууллагын хүрээнд тус байгууллагад ажиллаж байгаа тусгай мэдлэг бүхий хүн шинжээчээр ажиллан шинжилгээг хийж, дүгнэлтийг гаргана. Гэтэл тухайн мэргэжлийн байгууллагын хүлээх үүрэг хариуцлагатай холбоотой зохицуулалт байхгүй байна. Зөвхөн шинжээчийн эрх үүрэг, хариуцлагыг хуульд нарийвчлан тусгасан байна. Өөрөөр хэлбэл мэргэжлийн байгууллага шинжилгээг хийхтэй холбоотой нарийвчилсан зохицуулалтыг хуулийн төсөлд тусгаагүй байгааг анхаарах шаардлагатай байна.

Түүнчлэн хуулийн төслийн 11 дүгээр зүйлд шинжээчийн үйл ажиллагааны, эсхүл шинжилгээ хийх эрх олгох зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох нөхцөл болон зохицуулалтыг тусгасан боловч ямар процессийн хүрээнд түдгэлзүүлэх, шинжилгээ хийх эрх олгогдсон шинжээчийн гаргасан дүгнэлтийг хэн хянах, шинжээчийн үйл ажиллагааны зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тохиолдолд хэрхэн яаж сэргээх талаар зохицуулалт тодорхойгүй байна.

Мөн хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.4.1, 11.5.4, 11.5.5-д шинжээчийн үйл ажиллагааны зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгохдоо шинжээчийн үүргээ биелүүлээгүй, шаардлага хангаагүй дүгнэлт гаргасныг хэрхэн, хэн тогтоох нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл хуулийн төслөөс дүгнэхэд шинжилгээ хийх эрх олгогдсон шинжээчийн гаргасан дүгнэлтийг хууль тогтоомж, стандартад нийцэж байгаа эсэхийг хянах эрх бүхий этгээд байхгүй байна.

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.1-д шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгохоор заасан нь мөн төслийн 51 дүгээр зүйлийн 51.10-т Шинжилгээний төв байгууллага үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх нэгжээс гадна сургалт явуулах, шинжилгээ хийх эрх олгох, ...нэгжтэй байхаар заасантай нийцэхгүй байгааг анхаарах шаардлагатай байна.

Иймд хуулийн төслийн дээрх хийдэл, зөрчлийг арилгах үүднээс шинжээчийн гаргасан дүгнэлтийг хянах эрх бүхий этгээдийг тодорхой болгож, эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх, шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг шүүх шинжилгээний төв байгууллагаас олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх, түүнчлэн нэр томъёог жигдлэх шаардлагатай байна.

- о Эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны явцад хийх шинжилгээний зарим онцлог зохицуулалт болох инженер-техникийн шинжилгээ, хөрөнгийн үнэлгээнд хийх шинжилгээ, цахим технологийн шинжилгээ хийх зохицуулалт, журмыг шинээр тусгах хүрээнд:

Хуулийн төслийн Дөрөвдүгээр бүлэгт Зарим төрлийн шинжилгээний онцлогийг тусгасан. Тухайлбал төслийн 32 дугаар зүйл Криминалистикийн шинжилгээнд тавигдах тусгай шаардлага, 33 дугаар зүйл Шүүх эмнэлгийн шинжилгээнд тавигдах тусгай шаардлага, 34 дүгээр зүйл Эдийн засгийн шинжилгээнд тавигдах тусгай шаардлага,

Хөрөнгийн үнэлгээний шинжилгээнд тавигдах тусгай шаардлага, Цахим технологийн шинжилгээнд тавигдах тусгай шаардлага, 37 дугаар зүйл Инженер-техникийн шинжилгээнд тавигдах тусгай шаардлага, 38 дугаар зүйл Хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээ, шинжилгээнд тавигдах тусгай шаардлага, 39 дүгээр зүйл Сэтгэцийн шинжилгээнд тавигдах тусгай шаардлага, 40 дүгээр зүйл Сэтгэцэд учирсан хор уршгийн тооцох үнэлгээ зэрэг нийт 8 төрлийн үнэлгээ, шинжилгээнд тавигдах тусгай шаардлагыг тогтоож өгсөн байна.

Хуулийн төслийн 32 дугаар зүйлийн 32.1-д шинжилгээнд ирүүлж байгаа баримт материалыг эх хувиар ирүүлэхээс гадна биет байдлаар, эсхүл хуульд заасан тусгай шаардлага хангасан байхаар шинээр нөхцөл оруулж өгсөн нь практикт гардаг хийдлийг арилгахаар байна. Түүнчлэн бусад шинжилгээний онцлогийг хуулийн төсөлд тусгахдаа тухайн шинжилгээний объектод тавигдах шаардлага, шинжилгээг хийхдээ ямар баримт материалд хийх, шинжилгээг ямар үндэслэлээр хийх зэрэг шаардлагыг нарийвчлан оруулсан байна.

Мөн шинжилгээ хийхтэй холбоотой нарийвчилсан журмыг батлах эрх бүхий этгээдийг хуулийн төсөлд тодорхойлж оруулсан байна.

Харин хуулийн төслийн дээрх зүйлүүдэд заасан шинжилгээ хийх нөхцөлд “хуульд заасан бусад тохиолдолд” гэж оруулсан нь мөн хуульд заасан нөхцөлөөс гадна ямар хуульд заасан ямар нөхцөлд тухайн шинжилгээ хийх нь тодорхойгүй байна.

Өөрөөр хэлбэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад процессийн хуульд заасан нөхцөлийг Шүүх шинжилгээний тухай хуулийн төсөлд бүгдийг тусгасан бөгөөд уг хууль заасан нөхцөлөөр тухайн шинжилгээг хийх тул хуулийн төслийн 34.1.4, 35.2.4, 38.1.4, 38.6.4, 39.1.8-д заасан “хуульд заасан бусад” гэсэн заалт шаардлагагүй дүгнэж байна.

Иймд хуулийн төслийн дээрх заалтад тусгасан “хуульд заасан бусад” гэснийг хасах нь зүйтэй байна.

- о Хүрээлэн байгаа орчин болон сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлөх төлбөрийг тогтоох үнэлгээг хийх эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинээр бүрдүүлэх хүрээнд:

Хуулийн төслийн зорилтыг шүүх шинжилгээ хийх, хүрээлэн байгаа орчны хохирлыг тооцох болон сэтгэцэд учирсан хор уршгийн үнэлгээг тооцох, шинжилгээ хийх эрх олгох үндэслэл, журам болон шүүх шинжилгээний байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, алба хаагчийн эрх зүйн байдлыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахаар тодорхойлсон бөгөөд хуулийн төслийн 38 дугаар зүйлд Хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээ, шинжилгээнд тавигдах тусгай шаардлагыг тусгасан.

Хуулийн төслийн 38 дугаар зүйлээс үзэхэд хоёр тусдаа зүйлийг зохицуулсан байна. Үүнд:

- Хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээг хийж, хохирлыг мөнгөн дүнгээр тооцох,

- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний дүгнэлт, тайлан, магадлагаанд шинжилгээг хийх

Хуулийн төслийн 38.1-д шинжилгээний байгууллага эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргаан хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад дараах нөхцөл байдал илэрсэн тохиолдолд шинжилгээ хийлгэх шийдвэрээр хүрээлэн байгаа орчинд учирсан хохирол тооцох үнэлгээг байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрээр хийхээр тусгасан байна. Мөн зүйлийн 38.1.1, 38.1.2, 38.1.3-т тухайн үнэлгээг хийх тохиолдлыг тодорхойлж өгсөн байна.

Харин хуулийн төслийн 38 дугар зүйлийн 38.6-д Эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргаан хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад дараах нөхцөл байдал илэрсэн тохиолдолд байгаль орчны нөлөөллийн үнэлгээний шинжилгээг шинжилгээний байгууллага хийхээр тусгасан байна.

Үүнээс дүгнэхэд хоёр зарчмын асуудлыг анхаарах нь зүйтэй байна. Нэгт шүүх шинжилгээний байгууллага хүрээлэн байгаа орчны хохирлыг тооцох үнэлгээг хийх зайлшгүй шаардлагатай эсэх, хоёрт шинжилгээний байгууллагаас хүрээлэн байгаа орчинд учирсан хохирлыг тооцох үнэлгээг хийсэн бол шинжилгээний байгууллага тухайн үнэлгээг үнэн зөв бодитой хийгдсэн эсэх шинжилгээг хийж дүгнэлт гаргах нь хэр зохимжтой эсэхийг анхаарах. Нэг байгууллагаас хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээг хийсний дараа тухайн үнэлгээг үнэн зөв хийгдсэн эсэх талаар шүүх шинжилгээний байгууллагын шинжээч шинжилгээг хийж дүгнэлт гаргах нь хуулийн төслийн 5.1.3-т заасан хараат бус байх шинжилгээний үйл ажиллагааны зарчимтай нийцэх эсэх нь эргэлзээтэй байна.

Түүнчлэн хэрэв шүүх, прокуророос шүүх шинжилгээний байгууллагыг процессын хуульд заасан үндэслэлээр татгалзан гаргасан тохиолдолд ямар байгууллагаар хүрээлэн байгаа орчны хохирол тооцох үнэлгээ, шинжилгээг хийлгэх нь тодорхойгүй байна.

Иймд хуулийн төсөлд дээрх саналын дагуу холбогдох зохицуулалтыг хийх нь зүйтэй байна.

- о Сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлөх төлбөрийг тогтоох үнэлгээг шүүхээс хэрэглэхдээ сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох жишиг аргачлалыг баримтлах, уг аргачлалыг батлах субъектыг тодорхой болгох хүрээнд:

Хуулийн төслийн 40 дүгээр зүйлд Сэтгэцэд учирсан хор уршгийг тооцох үнэлгээ хийхээр заасан бөгөөд 40.1-д шинжилгээний байгууллага зөвхөн Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хүний амь нас хохирох, бие эрхтэнд гэмтэл учрах, бэлгийн эрх чөлөөний эсрэг, ялгаварлан гадуурхалт, хүүхдийн эсрэг, хүрээлэн байгаа орчны эсрэг, эрүү шүлт тулгах, үндэслэлгүйгээр хорих, залилах, хулгай, дээрэмдэх, заналхийлэх гэх зэрэг нийт 14 бүлгийн 84 гэмт хэргийн улмаас сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоохоор заасан байна.

Түүнчлэн хуулийн төслийн 40.2-т сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож дүгнэлт гаргахдаа дээр дурдсан гэмт хэргийн хохирогч байх, гэмт хэргийн улмаас

сэтгэцийн өөрчлөлтөд орсон байх, хохирогчийн сэтгэцийн шинжилгээг хийж, сэтгэцэд учирсан хямрал, эмгэгийг тогтоосон байх, сэтгэцэд учирсан хор уршиг нь шууд хохирогчид, эсхүл шууд бус хохирогчид учирсан байх, түр зуурын шинж, эсхүл байнгын шинж чанартай хор уршиг сэтгэцэд учирсан байх, сэтгэцийн хор уршгийг тодорхойлохдоо тухайн нөхцөлд учирсан хор уршгийг тогтоосон байхыг харгалзан үзэхээр заасан байна. Харин сэтгэцийн хор уршгийг зэргийг тогтоох дүгнэлт гаргах журмыг батлах эрх бүхий этгээдийг хуулийн төслийн 40.3-т тодорхойлсон байна.

Хуулийн төслийн дээрх зохицуулалтыг дүгнэхэд Иргэний хуульд заасан эдийн бус гэм хор буюу сэтгэл санааны хохирол, хүний нэр төр албан тушаалын нэр төрд учирсан хохирлыг арилгах талаарх зохицуулалтыг нарийвчлан ялангуяа сэтгэцэд учирсан хор уршгийг (сэтгэл санааны хохирол) зэрэглэлийг тогтоож, уг хор уршгийг арилгах нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох урьдач нөхцөлийг тодорхойл өгсөн зохицуулалт болжээ.

Гэхдээ хуулийн төслийн 40 дүгээр зүйлийн гарчиг нь тухайн зүйлийн агуулгатай нийцэхгүй байгааг анхаарах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл 40 зүйлийн зохицуулалт нь сэтгэцийн хор уршгийг зэргийг тогтоох, түүнийг тогтоохдоо юуг харгалзан үзэх талаар тусгасан бол 40 дүгээр зүйлийн гарчиг нь “Сэтгэцийн хор уршгийг тооцох үнэлгээ” гэж томъёолсон нь нийцэхгүй байна.

Түүнчлэн хуулийн төслийн 40 дүгээр зүйлийн 40.2.6-д сэтгэцийн хор уршгийг тодорхойлохдоо тухайн нөхцөлд учирсан хор уршгийг тогтоосон байх шаардлагыг тусгасан нь ойлгомжгүй бөгөөд мөн зүйлийн 40.2.2-т заасан гэмт хэргийн улмаас сэтгэцийн өөрчлөлтөд орсон байх, 40.2.3-т хохирогчийн сэтгэцийн шинжилгээг хийж, сэтгэцэд учирсан хямрал, эмгэгийг тогтоосон байх шаардлагатай агуулгын хувьд давхардаж байгааг анхаарах зүйтэй байна.

Гэмт хэргийн улмаас нас барсан иргэний сэтгэцийн хор уршгийг арилгах нөхөн төлбөрийг авах эрх бүхий этгээдийг тодорхойлохтой холбоотойгоор хуулийн төслийг даган боловсруулсан Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд Иргэний хуулийн 508 дугаар зүйлд нэмэлтээр оруулсан 508.5, 508.6 дахь хэсэгт нөхөн төлбөрийг нас барсан хүнтэй хамт амьдарч байсан гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, эсхүл насанд хүрээгүй гишүүний хууль ёсны төлөөлөгчөөр томилогдсон этгээд авахаар тусгасан байна.

Гэтэл дээрх өөрчлөлт нь Иргэний хуулийн 508 дугаар зүйлийн 508.1-д Хохирогч нас барсан бол түүнийг оршуулахтай холбогдсон зайлшгүй зардал болон гэм хор учруулсны төлбөрийг түүний өв залгамжлагч шаардах эрхтэй байхаар заасантай нийцэхгүй байна. Өөрөөр хэлбэл Иргэний хуулийн 508.1-д хохирогч нас барснаар сэтгэцийн хор уршгийг арилгах нөхөн төлбөрийг өв залгамжлагч нь авахаар заасан байна.

Түүнчлэн Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2-т бүтэн өнчин болсон бага насны хүүхдэд олгох сэтгэцийн хор уршгийн нөхөн төлбөрийн хэмжээг насанд хүрсэн хүний нөхөн төлбөрийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлж олгохоор тодотгон заасан байна. Харин Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас бүтэн өнчин болсноос бусад бага насны хүүхдийн сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах нөхөн төлбөрийн хэмжээг хэрхэн тооцох, хохирогч нас барсан бол сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах нөхөн төлбөрийг цуг амьдарч байсан

хүмүүсээс яг хэнд олгох, хэдий хэмжээгээр олгох, хүн тус бүрд олгох уу, эсхүл нэг хүнд олгох уу гэдэг нь тодорхойгүй байна.

Иймд Шүүх шинжилгээний хуулийн төсөл болон уг хуулийг даган боловсруулсан хуулийн төсөлд холбогдох өөрчлөлтийг оруулах шаардлагатай байна.

- о Шүүх эмнэлгийн төлбөртэй явуулж байсан шинжилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх, төрийн байгууллагаас үзүүлсэн үйлчилгээнд улсын тэмдэгтийн хураамжийг авах зохицуулалтыг тусгах хүрээнд:

Шүүх шинжилгээний тухай хуулийн төслийн 21 дүгээр зүйлд шинжилгээний хураамж, зардлын талаарх зохицуулалтыг тусгасан байна. Тухайлбал, төслийн 21.1-д “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 5.1.48, 5.1.49-д заасны дагуу зарим төрлийн шинжилгээг хийлгэхэд улсын тэмдэгтийн хураамж авна.”, 21.2-т “энэ хуулийн 21.1-д зааснаас бусад шүүх эмнэлгийн шинжилгээний хураамжийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.”, 21.3-т “Шинжилгээний байгууллагаас бусад байгууллагад ажиллаж байгаа этгээдийг шинжээчээр томилон ажиллуулсан тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 53.1.1, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 44.3.1, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.11 дүгээр зүйлийн 1.1, 2, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.4 дүгээр зүйлийн 1.1, 11.5 дугаар зүйлийн 1, 2-т заасны дагуу шинжээчийн зардлыг төлнө.” гэж тусгасан байна.

Шүүх эмнэлгийн шинжилгээний нийт 16 төрлийн шинжилгээг төлбөртэй хийж байсан бөгөөд үүнээс насанд хүрээгүй хүний шүүх эмнэлгийн шинжилгээнд төлбөр авахгүй байхаар шийдвэрлэсэн байдаг.

Хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасан Улсын тэмдэгтийн хураамжийн төлбөрийн тухай хуулийн 5.1.48, 5.1.49 дэх заалтыг эшлэсэн байна.

Харин Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.48, 5.1.49 дэх заалтууд нь Шүүх шинжилгээний тухай хуультай хамааралгүй зөвшөөрөл олгох заалтууд буюу Кино урлагийг дэмжих тухай хууль, Соёлын тухай хуульд заасан зөвшөөрлийг олгох талаарх заалт байх тул эшлэл буруу авсан байна.

Мөн хуулийн төслийн 21.2-т улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд ороогүй эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх боломжтой зарим шүүх эмнэлгийн шинжилгээг Эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлж болохоор заасан бөгөөд энэхүү зохицуулалттай уялдуулан Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Гэтэл шүүх эмнэлгийн шинжилгээ тэр тусмаа цогцост хийгдэх шинжилгээ нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэгэн адил эрүүл мэндийн даатгалд хамрагдах эсэх эргэлзээтэй байна. Түүнчлэн эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлдөггүй, даатгалд хамрагдахгүй Монгол Улсын иргэн болон гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний шүүх эмнэлгийн шинжилгээг хэрхэн шийдвэрлэх зохицуулалт хуулийн төсөлд байхгүй байна.

Иймд Шүүх шинжилгээний тухай хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.1, уг хуулийн төслийг даган боловсруулсан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “5.1.48, 5.1.49” гэсэн эшлэлийн дугаарлалтыг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн холбогдох заалттай (5.1.48, 5.1.49 дэх заалт, 20¹.1 дэх хэсэг) нийцүүлэх шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт хураамж авах шүүх эмнэлгийн шинжилгээний жагсаалт, хураамжийн хамт заасан 20¹ дүгээр зүйлийг нэмж тусгасан тул Шүүх шинжилгээний тухай хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “5.1.48, 5.1.49” гэснийг “20¹.1” гэж өөрчлөх шаардлагатай байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас болон сангаас санхүүжүүлэх боломжгүй шүүх эмнэлгийн шинжилгээний төлбөртэй холбоотой зохицуулалтыг ялган тусгах шаардлагатай байна.

- о Шүүх шинжилгээний байгууллага, түүний тогтолцоо, шинжилгээний байгууллагын ажилтны эрх зүйн байдлыг шинээр томьёолон оруулж, алба хаагчийн баталгааг нарийвчлан тодорхойлох талаар:

Шүүх шинжилгээний тухай хуулийн төслийн 51.1-д “Шинжилгээний байгууллага нь эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг маргааныг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлж, бэхжүүлэх, түүнд үзлэг, үнэлгээ, шинжилгээ хийж, дүгнэлт гаргах тусгай чиг үүрэг бүхий төрийн тусгай алба мөн.”, 51.2-т “Шинжилгээний байгууллагын тогтолцоо нь шүүх шинжилгээний төв байгууллага, түүний харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан шинжилгээний байгууллагаас бүрдэнэ.”, 51.5-д “Шинжилгээний байгууллага нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байна.”, 51.6-д “Шинжилгээний байгууллагыг нутаг дэвсгэрийн, эсхүл тойргийн зарчмаар байгуулж болно.”, 51.7-д “Энэ хуулийн 51.4-т заасан нутаг дэвсгэрийн зарчмаар нутаг дэвсгэр хариуцсан шинжилгээний байгууллагыг харьяалан ажиллах нутаг дэвсгэрийн хэмжээ, газар зүйн байршил, дэд бүтэц, хүн амын тоо, нягтаршил, хэрэг, маргааны тоо, бусад онцлогийг харгалзан байгуулна.”, 51.8-д “Нутаг дэвсгэр хариуцсан шинжилгээний байгууллагыг тойргийн зарчмаар байгуулахдаа харьяалан ажиллах нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, хэрэг, маргааны тоог харгалзан байгуулна.” гэж заасан байна.

Шүүх шинжилгээний байгууллагын тогтолцоог агентлагийн статустай болгон өргөжүүлсэн зохион байгуулахаар Шүүх шинжилгээний тухай хуулийн төсөлд болон Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний гэсэн хэсэгт өөрчлөлт оруулах төслийг боловсруулсан байна.

Одоогоор шүүх шинжилгээний байгууллага нь Засгийн газрын 2003 оны 63 дугаар тогтоолд зааснаар Хууль зүй, дотоод хэргийн яамны эрхлэх асуудлын хүрээний харьяа газрын статустайгаар 2021 онд нийт 220 алба хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байгаа бөгөөд орон нутагт аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний газар, сум, дүүрэгт цагдаагийн хэлтсийг түшиглэн хэлтэс, нэгжтэй ажиллаж байна. Харин нийслэлийн шүүхийн шинжилгээний албанд 99, аймгийн шүүхийн шинжилгээний албанд 231 алба хаагч буюу улсын хэмжээгээр нийт 594 алба хаагч ажиллаж байна. Дээрх шүүхийн

шинжилгээний байгууллагын алба хаагч нь жилд дунджаар 64300- 69977 шүүхийн шинжилгээг хийж, дүгнэлтийг гаргаж байна.

Шинжилгээний төрөл	Он				
	2016	2017	2018	2019	2020
Криминалистикийн шинжилгээ	14622	13202	13421	12121	10693
Шүүх эмнэлгийн шинжилгээ	40423	38090	39084	40181	36926
Тусгай шинжилгээ	13224	14002	15886	17438	16442
Эдийн засгийн шинжилгээ	256	231	233	237	260
Нийт шинжилгээ	68525	65525	68624	69977	64321

Өөрөөр хэлбэл шинжилгээний байгууллагын шинжилгээний нэг алба хаагч буюу шинжээчид ногдох ажлын ачаалал их байгаа юм. Тухайлбал, жилд дунджаар 16000 гаруй тусгай шинжилгээ хийгдэж байгаа бол тусгай шинжилгээ хийдэг шинжээчийн ачаалал физикийн шинжилгээ хийхэд 645, биологийн шинжилгээ хийхэд 6589 шинжилгээг хийж байна. Энэ мэтээр шинжилгээний байгууллагын шинжээчийн үйл ажиллагаанд өндөр ачааллыг үүсгэснээр шинжилгээний үр дүнд сөргөөр нөлөөлөхөөр байна.

Шинжилгээний төрөл	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	Нийт	Нэг жилийн дундаж ачаалал
Биологи	904	1057	1700	1465	1463	6589	1318
Хими	842	817	925	1391	988	4963	993
ДНХ	400	465	402	488	471	2226	445
бактериологи	788	1003	631	904	976	4302	860
Физик	220	83	98	118	126	645	129

Түүнчлэн орон нутаг хариуцсан шинжилгээний байгууллага нь аймаг, нийслэлийн шинжилгээний алба, сум, дүүргийн цагдаагийн хэлтсийг түшиглэн шүүхийн шинжилгээний байгууллагын нэгжийг ажиллуулж байна.

Харин хуулийн төсөлд зааснаар хэрэгжүүлэгч агентлаг болгож, нутаг дэвсгэр хариуцсан шинжилгээний байгууллагатай байх, уг байгууллагыг байгуулахдаа нутаг дэвсгэрийн зарчмыг байгуулахаас гадна, тойргийн зарчмыг баримтлахаар заасан нь цагдаагийн хэлтсийг түшиглэн нутаг дэвсгэрийн зарчмаар байгуулагддаг байсныг өөрчлөн зарим жижиг засаг захиргааны нэгжид тойргийн зарчмаар буюу харьяалан ажиллах нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, хэрэг, маргааны тоог харгалзан тогтоох шинэлэг үр дүнтэй зохицуулалт болжээ.

Нөгөө талаас дүүрэг, сумын шинжилгээний нэгж нь цагдаагийн байгууллагын газар, хэлтсийг түшиглэн байгуулагдсаныг өөрчлөн тойргийн, газар нутгийн зарчмыг баримтлан

байгуулахаар заасан нь шүүхийн шинжилгээний хараат бус байдалд сайнаар нөлөөлөхөөр байна.

Харин хууль хэрэглээний хүрээнд орон нутаг хариуцсан шинжилгээний байгууллагын орон тоог нарийвчлан тогтоох нь зүйтэй байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчийг хуулийн төслийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Шинжилгээний байгууллагын алба хаагчийн тангараг өргөж, шинжилгээний байгууллагад томилогдон ажиллаж байгаа төрийн тусгай алба хаагчийг шинжилгээний байгууллагын алба хаагч гэнэ.” гэж эрх зүйн байдлыг тодорхойлсон бөгөөд тусгай алба хаагч болохыг хувьд тавигдах шаардлага, хэрэглэх цол, тэмдэг, дүрэмт хувцас, үнэмлэхээс гадна тусгай мэдлэг бүхий шинжээчийн хувь тавигдах шаардлага, албан тушаалын тодорхойлолт, бүрэн эрхийг түдгэлзүүлэх, албанаас чөлөөлөх, түр орлон гүйцэтгэх, оногдуулах сахилгын шийтгэл, халах, чөлөөлөх зэргийг тодорхойлж өгсөн байна.

Түүнчлэн шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчийн цалингийн хэмжээ, сүлжээг тогтоох эрх бүхий этгээд тодорхойгүй буюу Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.4-т заасан Улсын Их Хурлаас тогтоох, эсхүл 57.5-д заасан Засгийн газраас тогтоох тусгай алба хаагчийн жагсаалтад ороогүй байсан нь шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдлыг тодорхойгүй үлдээсэн байна.

Харин хуулийн төслийг даган боловсруулсан Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчийн цалингийн хэмжээ, сүлжээг цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчтай адилтган үзэж Засгийн газраас тогтоохоор заасан байна.

Хуулийн төслийн 68-74 дүгээр зүйлд шүүх шинжилгээний байгууллагын алба хаагчийн баталгааг нарийвчлан зааж өгсөн байна. Тухайлбал, хуулийн төслийн 68 дугаар зүйлийн 68.1-д “**Шинжилгээний** байгууллагын алба хаагч Төрийн албаны тухай хуульд заасан баталгаанаас гадна энэ хуульд заасан улс төр, хууль зүй, нийгэм, эдийн засаг, аюулгүй байдлын болон бусад баталгаагаар хангагдана.” гэж заасан бөгөөд энэ хуульд зааснаас бусад баталгааг Цагдаагийн албаны тухай хуульд заасан баталгаагаар хангахаар заасан байна.

Хэдийгээр шинжилгээний байгууллагын алба хаагчийг төрийн алба хаагч тэр дундаа тусгай алба хаагч болохын хувьд нийгмийн, хууль зүйн, эдийн засгийн аюулгүй байдлын баталгаагаар хангаж байгаа нь сайн хэрэг боловч баталгааны давхардлыг дахин нягтлах, хууль хэрэглээний явцад гарах хүндрэлийг дахин тооцож, хэрэгжихгүй байж болохоор баталгааг нягтлах шаардлагатай байна. Тухайлбал, Хуулийн төслийн 70 дугаар зүйлийн 70.4-т албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан шинжилгээний байгууллагын алба хаагч болон түүний хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэндэд аюул занал учирсан, эсхүл учирч болзошгүй тохиолдолд тэдгээрийн амь нас, аюулгүй байдлыг хамгаалуулна.” Гэж заасан нь хуулийн төслийн 73 дугаар зүйлийн 73.3-д “Шинжилгээний байгууллагын алба хаагч хэрэг маргаанд шинжээчээр оролцсонтой холбогдуулан аюулгүй байдлаа хамгаалуулах хүсэлтийг шүүх, шүүгч прокурор,

мөрдөгчид гаргаж болно.” гэж заасантай агуулгын хувьд давхардаж байгаа эсэхийг нягтлах нь зүйтэй байна.

Өөрөөр хэлбэл хуулийн төслийн 70 дугаар зүйлийн 70.4-т заасан баталгаа нь хууль зүйн баталгаа гэхээс илүүтэй шинжээчийн аюулгүй баталгаа бөгөөд хууль зүйн болон аюулгүй баталгаанд давхардан орсон байгааг өөрчлөх шаардлагатай байна.

Түүнчлэн хуулийн төслийн 71 дүгээр зүйлийн 71.2-т “Аймаг, сумын нутаг дэвсгэр хариуцсан шинжилгээний байгууллагад тасралтгүй ажиллаж байгаа алба хаагчид таван жил тутамд нэг удаа 30 сарын үндсэн цалинтай тэмцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг тухайн байгууллагаас олгоно.” гэж, 72 дугаар зүйлийн 72.2-т “Шинжилгээний байгууллагын алба хаагч өөр аймаг, хот суурин газарт шилжин ажиллах болсноос шалтгаалан түүний эхнэр /нөхөр/ хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрвэл түүний гэр бүлийг тэргүүн ээлжид түүний мэргэжлийн болон түүнтэй дүйцэхүйц ажлаар хангах бөгөөд ажлаар хангаагүй тохиолдолд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож улсын төсвөөс олгоно.”, 72.3-т “Ээлжийн ажил, үүрэг гүйцэтгэдэг шинжилгээний байгууллагын алба хаагчийг онцгой тохиолдолд илүү цагаар ажиллуулсан бол ажилласан цаг тутамд ногдох албан тушаалын цалинг олгоно.” гэж заасан нь төсвийн талаас хэрэгжихэд хүндрэлтэй байгаа анхаарах.

Түүнчлэн хуулийн төслийн 71 дүгээр зүйлийн 71.8.1-д заасан хөдөлмөрийн чадвараа алдалтын хувь, хэмжээг харгалзан олгох нөхөн олговрын хэмжээг 30, 60, 90 хувиар тооцохоор заасан нь Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.4 дэх заалтын төрийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэж байхад бие махбодод нь гэмтэл учруулсан буюу эрүүл мэндийг нь бусад хэлбэрээр хохироосноос хөдөлмөрийн чадвараа түр алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон бол түүний авч байсан цалин, тэтгэвэр, тэтгэмжийн зөрүүг хөдөлмөрийн чадвараа түр алдсан буюу тахир дутуугийн тэтгэвэр авч байсан нийт хугацаанд нөхөн олгож, хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр заасантай нийцүүлэхгүй байна.

Мөн хуулийн төслийн 71 дүгээр зүйлийн 71.6 дахь хэсэгт “10 жил” гэж заасан нь Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэгт “60 сар” гэж заасантай нийцэхгүй.

Иймд хуулийн төслийн холбогдох зохицуулалтыг дээр дурдсаны дагуу өөрчлөх нь зүйтэй байна.

1. Практикт хэрэгжих боломжтой эсэх:

Хуулийн төслийн 8, 11, 40, 48, 49 дүгээр зүйлд заасан зохицуулалтуудыг “**Практикт хэрэгжих боломж**” шалгуур үзүүлэлтээр шалган бодит байдалд хэрэгжих боломжтой эсэх, хэрэгжүүлэгч субъектүүдэд ачаалал, бэрхшээл учруулах эсэх, учирч болох эрсдэлийг буруулах арга зам байгаа эсэхийг тодруулахыг зорилоо.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд төрийн байгууллага болон иргэд, төрийн бус байгууллага, судлаачдын төлөөлөлтэй уулзаж, санал хүсэлтийг авсан.

Мөн холбогдох байгууллагуудын статистик мэдээ, хуулийн төсөлд ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийх замаар шалгасан болно.

➤ **Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн зохицуулалт:**

Хуулийн төслийн 8 дугаар зүйлээр Шүүх шинжилгээг хийх этгээдийг тодорхойлсон бөгөөд шүүх шинжилгээг хийх этгээдийн хийх шинжилгээний жагсаалтад санал өгөх этгээдийн ялгамжтай байдлаар тодорхойлж, батлах эрх бүхий этгээдийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байхаар томъёолсон байна. Үүнд:

- Шинжилгээний байгууллагад хийх шинжилгээний жагсаалтыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална,
- Шинжилгээний байгууллагаас бусад этгээдээр хийлгэж болох шинжилгээний жагсаалтыг шинжилгээний байгууллагын саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Шинжилгээний байгууллагын болон шинжилгээний байгууллагаас бусад этгээдийн хийх шүүх шинжилгээний жагсаалтыг баталсан тохиолдолд практикт хэрэгжих нь боломжтой.

Харин уг жагсаалтыг шүүхийн шинжилгээний байгууллагаас боловсруулах, эсхүл уг байгууллагаас саналыг авах, түүнийг үндэслэх нь зайлшгүй юм. Өөрөөр хэлбэл, хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.3 болон 8.4-т заасан шүүхийн шинжилгээний байгууллагаас жагсаалтын саналыг авах, эсхүл авахгүй байх ялгаа уг хэсгүүдэд харагдахгүй байна.

Түүнчлэн эрүүгийн, иргэний, арбитрын хэрэг маргаан, зөрчил шалган шийдвэрлэх явцад шүүх шинжилгээний байгууллагыг хууль заасан нөхцөлөөр татгалзан гаргах тохиолдолд хуулийн төслийн 8.3-т заасан жагсаалтад орсон шүүх шинжилгээг хийх эрх бүхий этгээд тодорхойгүй байгаа нь хуулийг хэрэгжүүлэх явцад хүндрэл гарч болзошгүй юм.

Мөн хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.2-т “шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээдэд тухайн хэрэгт хувийн ашиг сонирхолгүй тусгай мэдлэг эзэмшсэн хүн, энэ хуулийн 11.1-д заасны дагуу эрх авсан шинжээч, эсхүл тусгай мэдлэг эзэмшсэн мэргэжилтэн, мэргэжлийн байгууллага хамаарна.” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.6-д “шинжээч” гэж шүүх шинжилгээ хийж, дүгнэлт гаргахаар хуульд заасан журмын дагуу томилогдсон тусгай мэдлэг бүхий хүнийг” гэж нэр томъёоны хувьд зөрүүтэйгээр томъёолсон хуулийг хэрэглэхэд хүндрэл гарч болзошгүй юм.

Үүнээс дүгнэхэд “шинжээч, шүүх шинжилгээг хийх эрх бүхий бусад этгээд” зэргийг тодруулан нэр томъёог жигдлэн тодорхойлох, хуульд заасны дагуу шүүх шинжилгээний байгууллагыг татгалзан гарсан тохиолдолд зохицуулалтын талаар анхаарч, зохицуулалтын томъёоллыг тодруулах нь зүйтэй байна.

➤ **Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн зохицуулалт:**

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.1-д шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээдэд шинжилгээ хийх эрхийг тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн таван жилийн хугацаагаар олгохоор заасан байна.

Түүнчлэн хуулийн төслийн 11.4-т шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр түдгэлзүүлэхээр заасан бөгөөд түдгэлзүүлэх үндэслэлд шинжээч хуульд заасан шинжээчийн үүргээ биелүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүй дүгнэлт гаргасан бол, шинжээч Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан тохиолдолд эрх бүхий байгууллага эцэслэн шийдвэр гаргах хүртэл хугацаанд байхаар хамааруулсан байна.

Харин хүчингүй болгох үндэслэлд зөвшөөрөл эзэмшигч нас барсан, зөвшөөрлөө цуцлуулах хүсэлт гаргасан, хуурамч бичиг баримтаар зөвшөөрөл авсан, шинжээчийн дүгнэлт 3 удаа алдаатай гарсан, шинжээчийн ёс зүй, хууль тогтоомж, үйл ажиллагааны стандарт, дүрэм журам ноцтой зөрчсөн, түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаагүй, шинжээчийн иргэний эрх зүйн чадамжийг хязгаарласан, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг авсан, гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон зэргийг хамааруулахаар хуулийн төсөлд заасан байна.

Хуулийн төслийн 11.1-д “шинжилгээ хийх бусад этгээдэд” гэж заасан нь энэ хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан бусад этгээдэд хамаарах нийт 4 субъектыг хамруулахаар байна. Гэтэл уг хуулийн төслийн үзэл баримтлалд зааснаар зөвхөн хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан эрх авсан тусгай мэдлэг бүхий шинжээч байх ёстой.

Иймд хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг болон 8.2 дахь хэсгийн уялдааг хангах нь зүйтэй байна.

Мөн хуулийн төслийн 11 дүгээр зүйлд зөвшөөрлийг түдгэлзүүлэх болон хүчингүй болгох үндэслэлд шинжээчийн дүгнэлтийг алдаатай гаргасан, эсхүл хуулт тогтоомж, үйл ажиллагааны стандарт, дүрэм журам ноцтой зөрчсөн байх үндэслэлийг заасан боловч хэн, хэрхэн уг дүрэм журам, стандартыг зөрчсөн болохыг тогтоох, дүгнэлт гаргах эрх бүхий этгээд нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл эрх авсан шинжээчийн дүгнэлт нь шаардлага хангасан эсэх талаар болон дээр дурдсан бусад асуудлаар хэнд гомдол гаргах нь тодорхойгүй байна.

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд шинжилгээ хийх эрх олгох эрхийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүү олгохоор заасан нь мөн хуулийн төслийн 51 дүгээр зүйлийн 51.10-т шинжилгээний байгууллагын чиг үүрэгт “шинжилгээ хийх эрх олгох” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд шинжилгээ хийх эрхийг олгох эрх бүхий этгээдийг нэг мөр шийдвэрлэж хуулийн төслийн 11 дүгээр зүйлд заасан хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, эсхүл шүүхийн шинжилгээний байгууллагын даргаас олгохыг шийдвэрлэн зүйл хоорондын уялдааг хангах, мөн “шинжилгээ хийх эрх олгох”, “шинжээчийн

үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл”, “эрхийн гэрчилгээ” гэсэн нэр томъёог жигдлэх нь зүйтэй байна.

Түүнчлэн хуулийн төслийн 11.5.1-д шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч нас барсан тохиолдолд хүчингүй болгох үндэслэлд заасан байна. Зөвшөөрөл эзэмшигч нас барсан байх нь өөрөө хууль зүйн факт байх тул үүнийг шинжээчийн үйл ажиллагаа явуулах эрхийг хүчингүй болгох үндэслэлээс тусад нь томъёолон хуулийн төслийн 11 дүгээр зүйлд тусгах нь зүйтэй байна.

➤ **Хуулийн төслийн 40, 49 дүгээр зүйлийн зохицуулалт:**

Хуулийн төслийн 40 дүгээр зүйлд гэмт хэргийн хохирогчийн сэтгэцэд учирсан хор уршгийг тооцоход харгалзан үзэх нөхцөл, журам, тооцох аргачлалыг батлах эрх бүхий этгээд, сэтгэцийн хор уршгийг хамааруулан үзэх гэмт хэргийн жагсаалт зэргийг тусгажээ.

Харин уг зүйлийн гарчиг нь “Сэтгэцэд учирсан хор уршгийг тооцох үнэлгээ” гэж тодорхойлсон боловч мөн зүйлийн 40.2-т “сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож” гэж зөрүүтэй байдлаар томъёолсон нь ойлгомжгүй байдлыг бий болгож байна. Өөрөөр хэлбэл, сэтгэцэд учирсан хор уршгийг тооцох, эсхүл сэтгэцэд учирсан хор уршгийн зэргийг тогтоох нь тодорхойгүй байна.

Хор уршгийг тооцох, хор уршгийн зэргийг тооцох нь нэр томъёоны хувьд болон агуулга, үр дүнгийн хувьд мөн ялгаатай юм. Тухайлбал хор ургийг тооцох бол тухай хохирогчид учирсан хор уршгийг мөнгөн дүнгээр илэрхийлэх буюу шүүх шинжилгээний байгууллагаас сэтгэцэд учирсан хор уршгийг мөнгөн дүнгээр тогтоох агуулгыг илэрхийлж байна. Харин хор уршгийн зэргийг тогтоох нь тухайн хохирогчийн сэтгэцэд хэр хэмжээний хор уршгийг “гэмтэл” учирсныг тоон илэрхийллээр тодорхойлох бөгөөд харин үүнийг үндэслэн шүүгчээс хор уршгийг арилгах нөхөн төлбөрийн хэмжээг тогтоож өгөх нь зүйтэй юм.

Дээрх ойлгомжгүй, зөрчилтэй томъёолол нь уг хуулийн нэг гол үзэл баримтлал болох гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох үзэл баримтлалыг хуулийн төсөлд нэг мөр тусгах, хуулийг хэрэглэхэд хүндрэлтэй байдлыг үүсгэхээр байна.

Иймд холбогдох өөрчлөлтийг хуулийн төсөлд тусгах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл гарчгийг “Сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох үнэлгээ, шинжилгээ” гэж өөрчлөх нь зүйтэй гэж үзэж байна.

2. Ойлгомжтой эсэх:

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Шүүх шинжилгээний тухай хуулийн төсөл боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг гүйцэтгэлээ.

Мөн хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас ойлгомжтой болгох чиглэлээр ирүүлсэн санал байгаа эсхийг нягтлан, анализ хийсэн болно.

Шүүх шинжилгээний тухай хуулийн төсөл нь 2013 онд батлагдсан Шүүхийн шинжилгээний тухай хуулийн зохицуулалтыг өргөжүүлэх шаардлагатайг харгалзан Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд зааснаар хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлбэрээр бичигдсэн 11 бүлэг, 81 зүйлтэй байна.

Хуулийн төслийн бүтцийн дугаарлалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.7-д заасан хуульд заасан шаардлагыг хангасан байна.

Мөн тус хуулийн төслийг дагалдан боловсруулагдсан

1. Галт зэвсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
3. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
4. Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
5. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
6. Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт оруулах тухай;
7. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
8. Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай;
9. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
10. Цэргийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
11. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
12. Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
13. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
14. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
15. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
16. Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
17. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8 дахь хэсэгт заасан дугаарлалт болон хуулийн төслийн заалтын байршилд тавигдах шаардлагыг хангасан байна.

Харин хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т “Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахдаа анхдагч хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хамтад нь боловсруулна.” гэж заасан байх тул Шүүхийн шинжилгээний тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуульд оруулах өөрчлөлт болон Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн зохицуулалтыг дахин нягтлах шаардлагатай байна.

Тухайлбал, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлд “Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсгийн “албадан эрүүлжүүлэх, саатуулах байр, улсын онц чухал объектын хамгаалалтад болон замын хөдөлгөөн зохицуулалт, эргүүл, харуул, жижүүрийн албанд” гэснийг хассугай” гэж заасан нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх, үүнд хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байхаар заасантай нийцэх эсэхийг нягтлах нь зүйтэй байна.

Бие даасан санаа бүрийг тусгай зүйлд тусгаж, заалт нь нэг өгүүлбэрээр илэрхийлэгдсэн, төслийн бүтэц нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28.3-т заасанд нийцсэн байна.

Мөн хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх, үүнд хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх, 30 дугаар зүйлд заасан хэл зүй, найруулгын ерөнхий шаардлагад нийцсэн байна.

Гэвч хуулийн төслийн зарим нэр томъёог жигдлэх, найруулгыг ойлгомжтой томъёолох, хуулийн зүйл, заалт хоорондын уялдааг хангах, эш татсан зохицуулалтын зөрчлийг арилгах, үг үсгийн алдааг анхаарах, шаардлагатай байна.

Хуулийн төсөлд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Монгол Улсын Шадар сайдын ажлын алба, ХЭҮК, шүүх, прокурор болон холбогдох яамд, төрийн болон төрийн бус байгууллагууд зэрэг нийт 34 байгууллагаас^[1] ирүүлсэн саналд шүүлт хийж үзвэл төслийн бичвэрийн томъёоллын ойлгомжтой байдлыг сайжруулах талаар тодорхой саналуудыг ирүүлсэн байна.

Эдгээр саналыг харгалзан төслийн үг найруулга, бичвэрийн томъёоллыг ойлгомжтой болгоход анхаарах шаардлагатай байна.

Тухайлбал:

- Төслийн 21 дүгээр зүйлийн 21.3-т хуулийн төслийн 12.4.5 дахь заалтыг эш татсан нь хуулийн төсөлд “12.4.5” гэсэн заалт байхгүй байна;
- Хуулийн төслийн 8.3, 8.4 дэх хэсэгт заасан жагсаалтыг батлах субъект адил бөгөөд тухайн жагсаалтыг боловсруулах, саналыг харгалзах этгээд нь адил байх боломжтой бичвэрийг нэгтгэн томъёолох;
- Төслийн 4.1.6, 8.2, 11.1, 11.2, 26.2, 38 дугаар зүйл, 48.1.2-т хэсэгт заасан нэр томъёо зөрүүтэй байгааг хянах;
- Төслийн 71.8.1, 77.4, 77.6, 78.3, 79.3 дахь хэсгийг Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуультай нийцүүлэх;
- Хуулийн төслийн 70.3 дахь хэсэг нь 73.3, 73.4 дэх хэсэгтэй агуулгын хувьд давхардаж байгааг анхаарах.

4.Харилцан уялдаатай байдлыг хангасан эсэх:

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10 –т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурын дагуу үнэллээ:

о *Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх:*

д/д	Шалгах асуулт	Шаардлагыг хангасан эсэх
1	29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх	Үндсэн хуульд заасан зарчмыг хангахад чиглэсэн бөгөөд ямар нэгэн байдлаар зөрчилдөөгүй байна.
2	29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх	Төслийн зүйл, хэсэг, заалт хоорондоо зарчмын томоохон зөрчил байхгүй байна. Харин зарим нэг тодруулах, уялдааг хангах, сайжруулах шаардлагатай асуудлыг үнэлгээний Зөвлөмж хэсэгт тусгасан болно.
3	29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх	Энэхүү хуулийн төсөлд зүйл, заалт хооронд эшлэл хэрэглэсэн байна. Иймд хуулийн төслийн зохицуулалтын өөрчлөлт, засварыг харгалзан, эшлэлийг нягтлах нь зүйтэй байна.
4	29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх	Тус хуулийн төслийг дагаж нэмэлт, өөрчлөлт оруулах 19 хуулийн төсөл, 1 УИХ-ын тогтоолын төслийг боловсруулсан байна. Сангийн яамны саналын дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хасах нь зүйтэй байна.

- Аргачлалын 4.10-т заасан шалгуурыг хангасан эсэх:

д/д	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм	Хуулийн төслийн зохицуулалт нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг бүрэн хангаж байна.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.

	харилцаанд хамаарах хууль мөн эсэх		
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Тийм	Хуулийн төслийн 4 дүгээр зүйлээс гадна 9, 11, 12, 34, 38 дугаар зүйлд нэр томъёог Тайлбар хэлбэрээр туссан байна. Мөн хуулийн төслийн хэлэлцүүлэг болон төсөлд ирүүлсэн саналаас үзэхэд “мэргэжлийн байгууллага”, “шинжилгээний объект” зэрэг нэр томъёог найруулга, бичвэрийн томъёоллын хувьд ойлгомжтой болгох шаардлагатай гэжээ.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Тийм	Дүн шинжилгээний хүрээнд зарчмын зөрүүтэй ямар нэгэн асуудал илрээгүй бөгөөд тодруулах, нэмэлт хийх шаардлагатай зохицуулалт байна.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Үгүй	Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлд тусгасан агуулга нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 30.1 дэх хэсэгтэй нийцэж байгаа эсэхийг нягтлах,
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Тийм	Хуулийн төслийг хэрэгжүүлэгч субъектүүдийн эрх үүргийг ялган тодорхойлсон байна.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Тийм	Хуулийн төслийн зохицуулалтыг тодруулах, хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	-	Энэхүү зохицуулалтыг нарийвчлан тодорхой зарчмыг тогтоосон байна.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Тийм	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд “шүүх шинжилгээний хийх эрх” олгох, сунгахад төлөх тэмдэгтийн хураамж болон зарим төрлийн шүүх эмнэлгийн шинжилгээнд тэмдэгтийн хураамж авах зохицуулалтыг тусгасан.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол	Тийм	Хуулийн төсөлд тусгасан хязгаарлалт нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн,

	Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх		хуульд заасан зайлшгүй бөгөөд хүний хууль ёсны ашиг сонирхлыг хуулиас гадуур хөндөхгүй байх нөхцөлийг тусгасан байна.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	-	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой.
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй	Хуулийн төслийн тусгагдаагүй болно.
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй	Хяналтаар энэ төрлийн зөрчил илрээгүй. Тус төслийн зохицуулалт нь өмнөх эрх зүйн зохицуулалтын хүрээнд байсан тодорхойгүй, зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцаанд хөндлөнгийн зөвлөлийг оролцуулж тэдгээрийн санал, дүгнэлтээр шийдвэрлэхээр зохицуулсан, шинжилгээг хийх үйл ажиллагаа, шинжээчид тавигдах шаардлага, хориглох зүйл, нөлөөллийн мэдүүлэг гаргах зэргээр энэ төрлийн хүнд суртлыг арилгахад чиглэсэн дэвшилттэй зохицуулалтыг тусгасан гэж дүгнэж байна.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	-	Тухайн хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хууль, Төрийн албаны тухай хууль болон энэ хуулиар зохицуулсан байх тул нэмэлтээр оруулах шаардлагагүй байна.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль, бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зарчмын хувьд зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнуудын чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна.

Харин хуулийн төслийн зохицуулалтыг тодруулах, хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг нэмэлт зохицуулалтыг тусгах, нэр томьёог ойлгомжтой болгох шаардлагатай байгаа нь харагдаж байна.

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Энэхүү үр нөлөө тооцох үнэлгээг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулсан “Шүүх шинжилгээний тухай” хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хийлээ.

Үнэлгээнд хуулийн төсөл, үзэл баримтлалаас гадна статистик тоон үзүүлэлтүүд, тайлан мэдээлэл, холбогдох хууль тогтоомж, тэдгээрийн албан ёсны болон албан бус тайлбарууд болон хуулийн төслийн хэлэлцүүлэг, төсөлд өгсөн Засгийн газрын гишүүд болон төрийн байгууллага, төрийн бус байгууллагаас гаргасан санал зэрэг нэмэлт материалыг ашигласан болно.

Хуулийн төсөл нь дэвшүүлсэн зорилгоо хангасан эсэх, практикт хэрэгжих боломжтой эсэх, бусад хуулиудтай хэрхэн уялдсан, хуулийн төслийн найруулга, хэл зүй ойлгомжтой эсэх гэсэн шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараахь **Дүгнэлтийг** хийж, **Зөвлөмж** боловсрууллаа:

Дүгнэлт:

- **Зорилгод хүрэх байдал:** Хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн, холбогдох зохицуулалтыг тусгасан байна. Гэвч зохицуулалтыг илүү нарийвчлах, хэрэгжих боломжийг нь нэмэгдүүлэх, нийцлийг хангах зорилгоор зарим нэг нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.

- **Практикт хэрэгжих боломжийг хангасан байдал:** Хуулийн төсөлд шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг нэмж, нарийвчлан тусгах нь зүйтэй байна.

- **Ойлгомжтой байдал:** Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан хэлбэрээ боловсруулагдсан ойлгомжтой байна. Гэвч хуулийн төслийн зарим нэр томъёог жигдлэх, ойлгомжтой томъёолох шаардлагатай байна.

- **Харилцан уялдааг хангасан байдал:** Хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо болон Үндсэн хуультай зарчмын хувьд зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтны чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна. Харин тус хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулах, хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Зөвлөмж

Хуулийн төсөлд дараах агуулгын чанартай зохицуулалт нэмэх, тодруулах шаардлагатай байна.

Үүнд:

1. Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчлийн хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудад Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасан шинжилгээ хийхтэй холбоотой нийтлэг зохицуулалт, шинжээчийн эрх үүрэг, түүнд хориглох зүйл, шинжилгээний объектын талаарх зохицуулалт зэргийг агуулгын болон хэлбэрийн хувьд давхардуулан заасан Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.7 дахь заалтад бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн

нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх шаардлагатай нийцүүлэх;

2.Хуулийн төслийн 16 дугаар зүйлд шинжилгээ хийх жишиг хугацааг ерөнхий нэг хугацаа байхаар ойлгогдож байгаа өөрчилж, шинжилгээ хийх жишиг хугацааг шинжилгээний төрөл тус бүрээр гаргах байдлаар зохицуулалтыг тусгах, түүнчлэн уг хугацааг боловсруулах, эсхүл батлах эрх бүхий этгээдэд санал болгох этгээдийг тодорхой тусгах;

3.Хуулийн төслийн 30 дугаар зүйлийн 30.1 дахь хэсгийн “тав хүртэлх” гэсэн шинжээчдийн тооны хязгаарлалтыг хасаж, хоёроос дээш хэд ч тооны шинжээчдийн бүрэлдэхүүнтэй хийж болох нөхцөлийг хангах;

4.Хуулийн хуулийн төслийн 22 дугаар зүйлийн 22.3.5, 22.4.8-д “бусад” гэж тодорхойгүй “цонх” үүсгэсэн байгааг анхаарах нь зүйтэй байна. Энэ нь тухайн бусад ямар төрлийн мэдээлэл орох нь тодорхойгүй байгаа бөгөөд ямар мэдээллийг бүрдүүлэх, хадгалах, ашиглах хамгаалах нь мөн адил тодорхойгүй болж байх тул шинжилгээний адилтгал, мэдээллийн нэгдсэн болон төрөлжсөн санд орох мэдээллийг бүгдийг тоочих байдлаар хуулийн төсөлд тусгах;

5.Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг нь мөн хуулийн төслийн 51 дүгээр зүйлийн 51.10 дэх хэсэгтэй зөрчилдөж байх тул Шинжээчийн гаргасан дүгнэлтийг хянах эрх бүхий этгээдийг тодорхой болгож, эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх, шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг шүүх шинжилгээний төв байгууллагаас олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх, түүнчлэн нэр томъёог жигдлэх;

6.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад процессийн хуульд заасан нөхцөлийг Шүүх шинжилгээний тухай хуулийн төсөлд бүгдийг тусгасан бөгөөд уг хууль заасан нөхцөлөөр тухайн шинжилгээг хийх тул хуулийн төслийн 34.1.4, 35.2.4, 38.1.4, 38.6.4, 39.1.8-д заасан “хуульд заасан бусад” гэсэн заалт шаардлагагүй байх тул хуулийн төслийн дээрх заалтад тусгасан “хуульд заасан бусад” гэснийг хасах;

7.Шүүх, прокуророос шүүх шинжилгээний байгууллагыг процессын хуульд заасан үндэслэлээр татгалзан гаргасан тохиолдолд ямар байгууллагаар хүрээлэн байгаа орчны хохирол тооцох үнэлгээ, шинжилгээг хийлгэх нь тодорхойгүй тул хуулийн төсөлд холбогдох зохицуулалтыг хийх;

8.Шүүх шинжилгээний тухай хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.1, уг хуулийн төслийг даган боловсруулсан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “5.1.48, 5.1.49” гэсэн эшлэлийн дугаарлалтыг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн холбогдох заалттай (5.1.48, 5.1.49 дэх заалт, 20¹.1 дэх хэсэг) нийцүүлэх шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт хураамж авах шүүх эмнэлгийн шинжилгээний жагсаалт, хураамжийн хамт заасан 20¹ дүгээр зүйлийг нэмж тусгасан тул Шүүх шинжилгээний тухай хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “5.1.48, 5.1.49” гэснийг “20¹.1” гэж өөрчлөх, Эрүүл мэндийн даатгалын сангаас

болон сангаас санхүүжүүлэх боломжгүй шүүх эмнэлгийн шинжилгээний төлбөртэй холбоотой зохицуулалтыг ялган тусгах;

9.Хуулийн төслийн 71 дүгээр зүйлийн 71.6 дахь хэсэгт “10 жил” гэж заасан нь Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэгт “60 сар” буюу 5 жил гэж заасантай нийцэхгүй байх тул хуулийн төслийн холбогдох зохицуулалтыг дээр дурдсаны дагуу өөрчлөх;

10.Хуулийн төслийн зарим нэр томъёог жигдлэх, найруулгыг ойлгомжтой томъёолох, хуулийн зүйл, заалт хоорондын уялдааг хангах, эш татсан зохицуулалтын зөрчлийг арилгах, үг үсгийн алдааг анхаарах.

Тухайлбал,

- Төслийн 21 дүгээр зүйлийн 21.3-т хуулийн төслийн 12.4.5 дахь заалтыг эш татсан нь хуулийн төсөлд “12.4.5” гэсэн заалт байхгүй байна;
- Хуулийн төслийн 8.3, 8.4 дэх хэсэгт заасан жагсаалтыг баллах субъект адил бөгөөд тухайн жагсаалтыг боловсруулах, саналыг харгалзах этгээд нь адил байх боломжтой бичвэрийг нэгтгэн томъёолох;
- Төслийн 4.1.6, 8.2, 11.1, 11.2, 26.2, 38 дугаар зүйл, 48.1.2-т хэсэгт заасан нэр томъёо зөрүүтэй байгааг хянах;
- Төслийн 71.8.1, 77.4, 77.6, 78.3, 79.3 дахь хэсгийг Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуультай нийцүүлэх;
- Хуулийн төслийн 70.3 дахь хэсэг нь 73.3, 73.4 дэх хэсэгтэй агуулгын хувьд давхардаж байгааг анхаарах.

[1] www.legalinfo.mn. Сүүлийн нэвтрэлт 2021 оны 10 дугаар сарын 15

[2] “25.1.Дараах тохиолдолд хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулна:

25.1.4.тухайн хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцааны төлөв байдал, агуулгад ихээхэн өөрчлөлт гарч, түүнтэй уялдуулан хуулийг шинэчлэн батлах шаардлагатай болсон.”

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйл.

[3] www.legalinfo.mn. Сүүлийн нэвтрэлт 2021 оны 10 дугаар сарын 5

[4] Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 2.9 “... хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан нэг, эсхүл хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг сонгож болно”.

[5] Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт.

[6] Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйл.

[7] Шүүх шинжилгээний тухай хуулийн төсөл. www.mojha.gov.mn

[8] Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал. 2021 он.

[9] Төрийн мэдээлэл эмхтгэл 2010 оны №2.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Судалгаа, статистик мэдээлэл

1. Шүүхийн шинжилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан 2018 он ХЗДХЯ,
2. Шүүхийн шинжилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх үнэлгээ 2018 он, Хууль зүйн үндэсний хүрээлэн,
3. Хүний сэтгэл санааны хохирлыг хэрхэн тооцох аргачлал болон гадаад улсын
4. Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял эдэлсэн хүмүүсийн сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох нь, судалгааны тайлан 2010 он, Хууль зүйн үндэсний хүрээлэн,
5. Шүүх шинжилгээ сэтгүүл 2019 он 4-р улирал,
6. Шинжлэн магадлахуйн онол, эрх зүй, зохион байгуулалтын асуудал, 2019 он, Т.Очирбат
7. Гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг хэрхэн тооцох аргачлал, гадаадын зарим улсын туршлага /харьцуулсан судалгаа/ судалгааны тайлан 2021 он, Хууль зүй үндэсний хүрээлэн

Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, тушаалын жагсаалт

1. Монгол Улсын Үндсэн хууль;
2. Хууль тогтоомжийн тухай хууль;
3. Шүүхийн шинжилгээний тухай хууль;
4. Иргэний хууль;
5. Арбитрын тухай хууль;
6. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
7. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль;
8. Эрүүгийн хууль;
9. Зөрчлийн тухай хууль;
10. Захиргааны ерөнхий хууль;
11. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль;
12. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль;
13. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль;
14. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль;
15. Цагдаагийн албаны тухай хууль;
16. Цэргийн албаны тухай хууль;
17. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль;
18. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль;
19. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль;
20. Монгол Улсын шүүхийн тухай хууль;
21. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль;
22. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль;
23. Байгаль орчныг хамгаалах тухай хууль;
24. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль;
25. Төрийн албаны тухай хууль;
26. Галт зэвсгийн тухай хууль;

27. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
28. Монгол Улсын Их хурлын 2020 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 7 дугаар тогтоол;
Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол.